



# Инфляцын тайлан 2024 | 9-р сар



## АГУУЛГА

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ.....	3
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР .....	4
ТОЙМ.....	5
1. ИНФЛЯЦ .....	7
1.1. Инфляцын цаашдын төлөв .....	7
1.2. Инфляцын гүйцэтгэл.....	8
1.3. Төсөөллийн зөрүү.....	9
2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ .....	9
2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв .....	9
2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл.....	12
3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН.....	15
3.1. Хөдөлмөрийн зах зээл.....	15
3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл .....	16
3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд.....	16
3.2.2. Хүү.....	19
3.2.3. Валютын ханш.....	20
3.2.4. Хөрөнгийн зах зээл .....	21
3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр.....	23
4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН .....	25
4.1. Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл .....	25
4.2. Экспортын үнийн төлөв.....	26
4.3. Төлбөрийн тэнцэл .....	27

## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк **инфляцыг дунд хугацаанд жилийн 5 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг** зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг мөнгөний бодлогын арга хэрэгслүүдтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй харилцах харилцааны нээлттэй байдалд ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ, өртгийн хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтэд мэдээлж байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулснаар бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанканд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдод ирээдүйн талаар мэдээлэл өгөх, хүлээлтийг удирдахыг зорьдог.

Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого, репо санхүүжилт болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байна. Мөнгөний бодлогын шилжих механизм ёсоор банк хоорондын захын хүүний өөрчлөлт нь хадгаламж, зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц болон тэдгээрийн ирээдүйн төлөвийн талаарх хүлээлтэд нөлөөлдөг. Ингэхдээ бодлогын хэрэгсэл нь эцсийн зорилт болох эдийн засгийн идэвхжил, инфляцад тодорхой хугацааны хоцролттой нөлөөлдөг.

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү, банкуудын эх үүсвэрийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болж байна. Түүнчлэн бодлогын хүүний коридор системтэй уялдуулан мөнгөний бодлогын бусад хэрэгслүүдийн хүү тодорхойлогддог.

## МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2024 оны 9 дүгээр сарын 10, 13-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад орчны эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувь болгох;
2. Банкуудын төгрөгийн эх үүсвэрийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 10 хувьд хүргэх;
3. Бодлогын хүүгийн коридорыг бодлогын хүүгээс +2, -2 нэгж хувьд тогтоож өргөн болгох;
4. Банкны заавал байлгах нөөц тооцох сууриас хасаж тооцож буй зарим төрлийн эх үүсвэртэй холбогдох шийдвэрийг хүчингүй болгохоор тус тус шийдвэрлэлээ.

Мөнгөний бодлогын 2024 оны 9-р сарын 13-ны өдрийн мэдэгдлийн дэлгэрэнгүйг [эндээс](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр орж татан авах боломжтой.

## ТОЙМ

Эдийн засгийн идэвхжил, эрэлтийн болон зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц нэмэгдэж ирэх онд Төв банкны зорилтот интервалын дээд хязгаарын орчимд хэлбэлзэхээр байна. Эдийн засгийн өсөлтийг уул уурхай, тээврийн салбарын өндөр өсөлт, өрхийн болон төрийн хэрэглээ голлон тэтгэсэн ба хөдөө аж ахуйгаас бусад салбаруудын идэвхжлийг харгалзан өсөлтийн төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүллээ. Дэлхийн эдийн засгийн төлөвт төдийлөн өөрчлөлт гараагүй ч геополитикийн нөхцөл байдал, түүхий эдийн зах зээл дэх тодорхой бус байдал хэвээр байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо инфляц, эдийн засгийн өсөлтийн төлөв, банк, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, гадаад орчны төлөвийг харгалзан 2024 оны 9 дүгээр сард бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 10 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа. Энэхүү бодлогын шийдвэр гаргахад ашигласан эдийн засаг, зах зээлийн өнөөгийн байдал, суурь төсөөллийн тооцооллыг энэхүү тайланд тусгалаа.

**Энэ онд инфляцын төсөөлөл өмнөх төсөөллөөс буурч, ирэх оны төсөөлөл нэмэгдсэн ч зорилтын интервалд хэлбэлзэх хүлээлт хэвээр байна.** Инфляц 2024 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 6.5 хувь, Улаанбаатар хотод 6.2 хувьтай гарч Төв банкны зорилтын орчимд тогтвортой хадгалагдаж байна. Инфляцын төсөөллийг энэ онд өмнөхөөс бууруулахад мах, махан бүтээгдэхүүний үнэ төсөөллөөс буурч хүнсний инфляц саарсан, гадаад инфляц нам түвшинд хадгалагдахын зэрэгцээ төгрөгийн ханш тогтвортой байгаа нөлөөгөөр импортын барааны инфляц буурах төлөвтэй байгаа нь нөлөөлөв. Харин эдийн засгийн идэвхжил, төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр дотоод эрэлт идэвхжих зэргээс шалтгаалан дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нэмэгдэх төлөвт үндэслэн инфляцын төсөөллийг ирэх онд нэмэгдүүллээ. Эрэлтийн шинжтэй инфляцын эрч нэмэгдэх, гадаад үнэ өсөх, өрхийн цахилгаан, дулааны төлбөр нэмэгдэх суурь нөлөө зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц 2025 оны дундаас зорилтот интервалын дээд хязгаарт хүрч нэмэгдэх бөгөөд цаашид зорилтын голч руу алгуур буурах хүлээлттэй байна. Цахилгаан, дулааны үнэ өсвөл нэг талаас инфляцыг нэмэгдүүлэх хэдий ч нөгөө талаас хэрэглээний зардлыг нэмэгдүүлэн бусад хэрэглээг бууруулах нөлөө үзүүлэх тул эрэлтийн инфляцыг бууруулах нөлөөтэй. Энэхүү бууруулах нөлөөг суурь төсөөлөлд тусгаагүй болно.

**Эдийн засгийн өсөлтийн төлөв үргэлжлэн сайжрав.** Энэ оны эхний хагаст эдийн засаг 5.6 хувиар, 2-р улиралд 3.9 хувиар өсөж хүлээлтээс өндөр гарлаа. Үүнд уул уурхай, тээврийн салбарын өсөлт үргэлжлэн нэмэгдэж, аялал жуулчлал, үйлчилгээний салбарын өсөлт эрчимжсэн, бүтээгдэхүүний цэвэр татварын орлого өндөр байсан зэрэг нь голлон нөлөөллөө. Өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээ нэмэгдэн дотоод эрэлт тэлэх, нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх төсөөллөөс сайжрах, төсвийн төлөв сулрах зэрэг нөлөөг харгалзан үзэж эдийн засгийн өсөлтийн төсөөллийг энэ онд 5.5 хувьд хүргэж нэмэгдүүллээ. Ирэх онд зудын хүндрэл арилах, Оюу толгойн үйлдвэрлэл эрчимжих, төсвийн төлөв сулрах зэрэг нөлөөгөөр эдийн засгийн өсөлт өндөр хадгалагдах төлөвтэй байна.

**Гадаад орчны төлөв төдийлөн өөрчлөлтгүй байна.** Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв өмнөх төсөөллийн орчимд хадгалагдаж, 2024 онд дунджаар 3.1 хувиар өсөх тооцоололтой байна. Геополитикийн нөхцөл байдалтай холбоотой суурь эрсдэлүүд хэвээр хадгалагдаж, тодорхой бус байдал үргэлжилсээр байна. БНХАУ-ын дотоод эрэлт төсөөлөлд

хүрч сэргээгүй, үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилсэн нь тус улсын эдийн засгийн өсөлтийг саарах хүлээлтийг үүсгээд байна. АНУ-ын хувьд эдийн засгийн өсөлтийн төлөв өмнөх төсөөллийн орчимд хэвээр хадгалагдсан ба ирэх Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн цаашдын төлөвт чухал нөлөө үзүүлэхээр байна. Дээрх эрсдэл, тодорхой бус байдал болон улс орнуудын сэргээгдэх эрчим хүчний төсөл, ногоон шилжилттэй холбоотойгоор дэлхийн зах зээл дэх алт, зэсийн үнэ өндөр хэвээр хадгалагдахаар байгаа бол БНХАУ-ын төлөв болон нийлүүлэлтийн хүчин зүйлсээс шалтгаалж нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна.

**Төлбөрийн тэнцэл 2024 оны 2 дугаар улиралд 461 сая ам.доллар, эхний хагасын байдлаар 57 сая ам.долларын алдагдалтай гарлаа.** Дэлхийн зах зээл дээрх алт, зэсийн үнэ өндөр байж, нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь экспортын орлогыг тэтгэж байгаа ч дотоод эрэлт тэлж, хэрэглээ, хөрөнгө оруулалтын импорт эрчимжин урсгал данс тайлант улиралд 332.5 сая ам.долларын алдагдалтай гарав. Санхүүгийн дансны хувьд 2024 оны 2 дугаар улиралд 197 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон хувийн секторын гадаад зээлийн ашиглалт санхүүгийн дансны орох урсгалыг голлон бүрдүүлсэн бол нөгөө талаас дотоодын аж ахуйн нэгжүүдийн гадаад дансанд байршуулсан орлого хүлээлтээс өндөр байсан нь санхүүгийн дансны тэнцэлд сөргөөр нөлөөлөв. Түүнчлэн Монголбанк БНХАУ-ын Ардын банктай хийсэн своп хэлцлийн үндсэн төлбөрөөс 4.5 тэрбум юань буюу нийт төлбөрийн 37.5 хувийг төлсөн нь төлбөрийн тэнцлийн алдагдалд гол нөлөө үзүүллээ.

**Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт алгуур саарч байна.** 2024 оны 2 дугаар улиралд 31.9 хувьд хүрч нэмэгдээд байсан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 7 дугаар сарын байдлаар 30.4 хувьд хүрч буурахад гадаад валютын цэвэр орох урсгал саарч, банкны систем дэх гадаад цэвэр актив буурсан нь нөлөөлөв. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг актив талаас зээлийн өсөлт болон гадаад цэвэр актив голлон бүрдүүлж байгаа бол эх үүсвэр талаас төгрөгийн эх үүсвэр дийлэнх хувийг эзэлсэн хэвээр байна. Банкны системийн зээлийн жилийн өсөлт 2024 оны 7 дугаар сард 32.1 хувьд хүрч үргэлжлэн эрчимжихэд ипотек, бизнесийн болон цалингийн зээлийн өсөлт гол нөлөөг үзүүллээ. Түүнчлэн зээлийн чанар сайжирч, чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар буураад байна.

Энэ оны инфляцын төсөөлөл өмнөхөөс буурсан хэдий ч эдийн засгийн идэвхжил нэмэгдэж төсвийн төлөв сулрах хүлээлттэй байгаа нь ирэх оны инфляцын төсөөллийг нэмэгдүүллээ. Инфляц нэмэгдэн ирэх оны дунд үеэс Төв банкны зорилтот интервалын дээд хязгаарын орчимд хүрч хэлбэлзэх бөгөөд дунд хугацаанд зорилтын голч руу алгуур буурах хүлээлт хэвээр байна. Гэхдээ худалдааны түнш орнуудын инфляц, валютын ханш, төсвийн төлөв болон томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудын санхүүжилт зэрэг хүчин зүйлс нь инфляцын төлөвийг нэмэгдүүлэх эрсдэл өндөр байна. Цаашид эдийн засгийн идэвхжил, инфляцын өрнөл болон гадаад эдийн засгийн орчны өөрчлөлт зэргийг харгалзан үзэж мөнгөний бодлогын шаардлагатай алхмыг тухай бүрт авч хэрэгжүүлнэ.

## 1. ИНФЛЯЦ

### 1.1. Инфляцын цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2024 оны 9 дүгээр сард 1 нэгж хувиар бууруулж 10 хувьд хүргэх, 4 дүгээр улиралд хэвээр хадгалах;
- Банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 10 хувьд хүргэх;
- АИ-92 шатахуун авах гэрээний үнэ өөрчлөгдөхгүй;
- 11 дүгээр сараас өрхийн цахилгааны үнэ 30 хувиар, дулааны үнэ 50 хувиар өсөх гэсэн таамаглалт нөхцөлүүд дээр үндэслэн суурь төсөөллийг боловсрууллаа.

Инфляцын төсөөлөл энэ онд өмнөх төсөөллөөс буурч, ирэх онд нэмэгдэхээр байна. Мах, махан бүтээгдэхүүний үнэ хүлээлтээс бага өссөн, гадаад инфляц буурч, төгрөгийн ханш тогтвортой байснаар импортын барааны инфляц төсөөлснөөс бага гарсан зэргээс шалтгаалан энэ оны инфляцын төсөөллийг өмнөхөөс буурууллаа.


Ирэх онд төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр дотоод эрэлт тэлж, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт нэмэгдэх, дэлхийн хүнсний үнэ, гадаад инфляц өсөх зэрэг нөлөөгөөр инфляц өмнөхөөс нэмэгдэх төлөвтэй байна.

Инфляц 2024-2026 оны эцэст харгалзан 6.0 хувь, 7.8 хувь, 5.7 хувь байх төсөөлөлтэй байна.

Мах, махан бүтээгдэхүүний үнэ улирлын хандлагаа даган алгуур буурах, махнаас бусад дотоодын хүнсний инфляц харьцангуй тогтвортой байх нөлөөгөөр хүнсний инфляц оны сүүлийн хагаст

зорилтын голчийн орчимд тогтвортой байх хүлээлттэй байна. Харин төгрөгийн ханш алгуур суларч, худалдааны түнш орнуудын инфляц өсөх, өрхийн цахилгаан, дулааны төлбөр нэмэгдэх зэрэг нь хүнсний бус инфляцыг нэмэгдүүлэхээр байна.

Зураг 1.1 Инфляцын өмнөх болон одоогийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

Ирэх онд эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, төсвийн төлөв сулрах зэрэг нөлөөгөөр эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт нэмэгдэхээр байна. Худалдааны түнш орнуудын инфляц өсөж, ханш суларснаар, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх болон өрхийн цахилгаан, дулааны төлбөр нэмэгдсэн суурь нөлөө зэргээс үүдэн инфляц ирэх онд нэмэгдэж, зорилтын дээд интервалын орчимд байхаар байна. Гэхдээ ирэх оны төсвийн зардал өргөн барьсан дүнгээр батлагдаж, томоохон бүтээн байгуулалтын зардлыг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханшид ирэх дарамт нэмэгдэж, инфляц тооцоолсноос өндрөөр өсөх эрсдэл үүсэж болзошгүй юм.

Дунд хугацаанд дотоод эдийн засгийн идэвхжил тогтворжиж, эрэлтийн шалтгаантай үнийн дарамт буурах, гадаад үнэ саарах зэрэг нөлөөгөөр инфляц алгуур буурч, 2026 оны сүүлийн хагаст зорилтын голчийн орчимд тогтворжихоор байна.

Хүснэгт 1.1 Инфляцын төсөөлөл

	2024.И	2024*	2025*	2026*
		<i>Төсөөлөл</i>		
Инфляц <sup>1</sup>	5.5	6.0 [5.6-6.4] <sup>2</sup>	7.8 [6.8-8.6]	5.7 [4.9-6.3]

Эх сурвалж: Монголбанк

**Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал:**


Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
БНХАУ-ын эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж, гангийн зах зээлд сөрөг хүлээлт давамгайлж байна. Энэ нь манай улсын гадаад эрэлт, экспортын бүтээгдэхүүний үнэд сөргөөр нөлөөлж, гадаад валютын орох урсгалыг муутгах тохиолдолд, ханшийн сулрах дарамтыг нэмэгдүүлж, импортын үнээр дамжин инфляцыг эрчимжүүлэх эрсдэлтэй.	Дунд	Дунд
Манай улсын нүүрсний экспорт өндөр түвшинд хадгалагдаж байгаа ч үнэ ирэх онуудад буурч, экспортын орлого багасах хандлагатай байна. Нүүрсний үнэ төсөөлөлд авч үзсэнээс хурдтай буурах нөхцөлд төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж, төгрөгийн ханшийг сулруулж, инфляцыг өсгөж болзошгүй.	Дунд	Өндөр
Аж ахуйн нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдэж, үүний дам нөлөө бусад бараа, бүтээгдэхүүний үнэд хүчтэй нөлөөлвөл инфляц төсөөлснөөс нэмэгдэх эрсдэл үүснэ.	Дунд	Дунд

**1.2. Инфляцын гүйцэтгэл**

Инфляц II улиралд улсын хэмжээнд 5.7 хувь, Улаанбаатар хотод 5.5 хувьд хүрч, өмнөх улирлаас 1.5 болон 2.0 нэгж хувиар буурлаа. Ийнхүү инфляц сүүлийн 3 жилийн хамгийн бага түвшинд хүрэв. Дэлгэрүүлбэл, хүнсний бүлгийн инфляцад үзүүлэх нөлөө өмнөх улирлаас 1.0 нэгж хувиар, хүнсний бус бүлгийн инфляцад

үзүүлэх нөлөө өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар тус тус буурчээ.

Зураг 1.2 Инфляц



Эх сурвалж: УСХ

Инфляц II улирлаас бага зэрэг нэмэгдэж 8 дугаар сард улсын хэмжээнд 6.5 хувь гарлаа (Зураг 1.2).

Зураг 1.3, 1.4-т үзүүлсэнчлэн инфляцын хөдөлгөөнд голлон нөлөөлж буй бүлгүүдийг дэлгэрүүлж тайлбарлавал:

**Хүнсний үнийн** жилийн өсөлт сүүлийн саруудад бага зэрэг нэмэгдэж, 8 дугаар сарын байдлаар жилийн 7.3 хувьд хүрлээ. Энэ нь инфляцын 2.1 нэгж хувийг бүрдүүлж, II улирлаас 0.1 нэгж хувиар нэмэгдсэн дүн боллоо. Өнгөрсөн оны намрын саруудад махны үнэ эрчтэй буурсан суурь үе томоохон нөлөөтэй байв.

**Үйлчилгээний үнийн** инфляцад үзүүлэх нөлөө II улирлаас 0.5 нэгж хувиар нэмэгдэж, 2.0 хувьд хүрлээ. Үүнд, сүүлийн саруудад түрээс, боловсрол зэрэг үйлчилгээний үнэ нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тодруулбал, сургалтын төлбөр жилийн 18.6 хувиар болон орон сууцны түрээсийн төлбөр жилийн 23.7 хувиар өссөн нь томоохон нөлөөтэй байлаа.

<sup>1</sup> ХҮИ-ээр хэмжигдэх инфляц, IV улирал дахь сарын инфляцын дундаж


<sup>2</sup> 30 хувийн магадлалтай итгэх интервал.



Зураг 1.3 Инфляцад нөлөөлж буй хүчин зүйлс<sup>3</sup>

Эх сурвалж: УСХ, Монголбанк

**Импортын барааны үнийн жилийн өсөлт** тайлант сард 4.4 хувьд хүрч, өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар нэмэгдсэн байна. Хүнсний бус бараа, үүн дотроо, гэр ахуйн хэрэглээний бараа, хичээлийн хэрэгсэл зэргийн үнэ нэмэгджээ. Харин импортын хүнс, шатахууны үнэ сүүлийн саруудад тогтвортой хэвээр байна.

Зураг 1.4 Жилийн инфляц, бүрэлдэхүүнээр<sup>4</sup>

Эх сурвалж: УСХ, Монголбанк

### 1.3. Төсөөллийн зөрүү

Инфляц 2024 оны II улиралд төсөөлснөөс ялимгүй бага байв. Үүнд, хүнсний бүлэг, түүн дотроо махны үнэ хаврын саруудад харьцангуй тогтвортой байсан нь голлон нөлөөллөө.

<sup>3</sup> Нийт сагсны 46 хувь нь импортын бараа бүтээгдэхүүнээс бүрддэг. Үүний 44.8 хувийг БНХАУ, 21.7 хувийг ОХУ, 17.1 хувийг Япон, 7.6 хувийг БНСУ бүрдүүлж байна. ОХУ-ын бараа, бүтээгдэхүүний 50 хувийг шатахуун, Японы бараа, бүтээгдэхүүний 97 хувийг автомашин бүрдүүлж байна.

## 2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

### 2.1. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв

Төсөөлөлд ашигласан гол таамаглалт нөхцөлүүд:

- Бодлогын хүүг 2024 оны 9 дүгээр сард 1 нэгж хувиар бууруулж 10 хувьд хүргэх, 4 дүгээр улиралд хэвээр хадгалах;
- Банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 10 хувьд хүргэх;
- Төсвийн зардал 2024 оны төсвийн тодотголтой хамт өргөн барьсан 2025-2026 оны төсвийн төсөөллөөр тодорхойлогдоно;
- Нүүрсний экспортын биет хэмжээ 2024-26 онд өмнөх төсөөллөөс 8.3 сая.тн-оор нэмэгдэх;
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 2024 онд 296 сая ам.доллаар өмнөх оноос нэмэгдэх, 2025 онд 666 сая ам.доллар, 2026 онд 127 сая ам.доллаар өмнөх оноос тус тус буурах.

Эдийн засгийн өсөлт 2024 онд 5.5 хувь, 2025 онд 7.3 хувь, 2026 онд 4.9 хувьд хүрэх тооцоололтой байна (Хүснэгт 2.1). Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг нийлүүлэлт болон эрэлт талаас дараах хэсэгт тайлбарлав.

### Нийт нийлүүлэлт


Энэ онд эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна. Тодруулбал, дотоод эрэлт сайжирч, импорт өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байгаа нь худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр

<sup>4</sup> Үйлчилгээ, төрийн зохицуулалттай үйлчилгээний бүлгийг нэгтгэж “Үйлчилгээ”, хатуу түлш, бусад дотоодын бараа бүлгийг нэгтгэж “Дотоодын бараа”, мах, махнаас бусад дотоодын хүнсний бүлгийг нэгтгэж “Дотоодын хүнс”-ний бүлэг болгов.

татварын орлогыг дэмжих, төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын зардал тэлж, барилгын салбарын өсөлт өмнөхөөс нэмэгдэх зэрэг нь өсөлтийн төлөв сайжрах гол шалтгаан болж байна.

Ирэх онд нүүрсний экспорт өмнөх төсөөллөөс нэмэгдэж, тээвэр, худалдааны салбарын өсөлтийг дэмжих, төсвийн төлөв суларч нийт эдийн засгийн өсөлт идэвхжих хүлээлттэй байна (Зураг 2.1).

Зураг 2.1 4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

**Уул уурхай:** Энэ онд газрын тосноос бусад уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт өнгөрсөн оноос нэмэгдэж, уул уурхайн салбарын өсөлт 17.4 хувьд хүрэх төлөвтэй байна. Дунд хугацаанд Оюу толгойн үйлдвэрлэл эрчимжихийн зэрэгцээ нүүрсний олборлолт энэ оны өндөр түвшинд хадгалагдаж, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжихээр байна.

Хүснэгт 2.1 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл<sup>5</sup>

	2023	2024*	2025*	2026*
		Төсөөлөл		
ДНБ-ий өсөлт	7.4	5.5 [3.7-7.3]	7.3 [4.7-9.9]	4.9 [2.0-7.8]
Уул уурхай	23.4	17.4 [15.6-19.2]	18.5 [15.8-21.0]	4.5 [1.6-7.4]
Уул уурхайн бус	5.4	3.8 [2.0-5.6]	5.4 [2.8-8.0]	5.0 [2.1-7.9]

<sup>5</sup> 30 хувийн магадлалтай итгэх интервал.

Эх сурвалж: Монголбанк

**Уул уурхайн бус салбар:** Нүүрсний экспорт сайн байгаатай холбоотойгоор тээвэр, худалдаа зэрэг өмнөх онд эдийн засгийг тэтгэж байсан салбаруудын өсөлтийн эрч хадгалагдах, төсвийн тодотголын нөлөөгөөр дотоод эрэлт тэлж, импорт нэмэгдэн барилга, бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт эрчимжихээр авч үзлээ. Мөн байр, орон сууц, урлаг үзвэрийн үйлчилгээ идэвхжиж, зээлийн өсөлт нэмэгдэн санхүүгийн үйл ажиллагаа сайжирч байгаатай холбоотойгоор үйлчилгээний салбарын өсөлт өмнөх оноос сайжрахаар байна. Харин зудын нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбар 27 орчим хувиар агших хүлээлт хэвээр байна. Ийнхүү уул уурхайн бус салбарын өсөлт энэ онд 3.8 хувь, үүнээс ХАА-н салбарыг хасвал 9 хувьд хүрч эрчимжих төлөвтэй боллоо.

Ирэх онд уул уурхайн салбарын эерэг дам нөлөөнөөс гадна төсвийн төлөв сулрах, зудын хүндрэл арилах зэргээс шалтгаалан уул уурхайн бус салбарын өсөлт сайжрах төсөөлөлтэй байна. Харин 2026 оноос хөрөнгө оруулалт саарч, төсвийн төлөв чангарах, худалдааны нөхцөл муудах зэрэг нь өсөлтийн төлөвийг сааруулахаар байна.

### Нийт эрэлт

Өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээ өмнөх төсөөллөөс нэмэгдэж, энэ оны эдийн засгийн өсөлт өмнөхөөс сайжирлаа (Хүснэгт 2.2).

**Дотоод эрэлт:** Энэ онд дотоод эрэлт, үүн дотроо өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээ эдийн засгийн өсөлтийг голлон дэмжихээр байна. Тухайлбал, төрийн байгууллагын хэрэглээ эрчимжин 31.5 хувьд хүрч өсөх, цалин, тэтгэвэр, зээлийн өсөлтийг дагаад өрхийн хүнсний бус хэрэглээ өндөр байх хүлээлттэй байна.

Харин малын хорогдлын улмаас хөрөнгийн нийт хуримтлал дотоод эрэлтэд сөрөг нөлөөг үзүүлэхээр байна.

Ирэх онд төсвийн төлөв сулрах, эдийн засгийн идэвхжил нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт нийт эрэлтийн өсөлтөд голлох эерэг нөлөө үзүүлнэ.

**Цэвэр экспорт:** Энэ онд цэвэр экспорт өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Тодруулбал, нүүрс, алт, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг экспортын түүхий эдийн биет хэмжээ өмнөх оноос бага зэрэг нэмэгдэхээр байгаа ч нүүрсний экспорт өндөр байсан суурь үеийн нөлөөгөөр бараа, үйлчилгээний экспортын өсөлт өмнөх оноос саарахаар байна. Нөгөө талаас, нүүрсний экспорт нэмэгдсэнээс шалтгаалан түүнд ашиглагдах машин тоног, төхөөрөмжийн импорт ирэх улирлуудад нэмэгдэхээр байна. Түүнчлэн, төсвийн тодотгол, өрхийн хэрэглээний өндөр өсөлтөөс шалтгаалан бараа, үйлчилгээний импорт тэлэх төлөвтэй байна. Ийнхүү импортын өсөлт экспортын өсөлтөөс өндөр хадгалагдах нь нийт эрэлтийг бууруулах нөлөө үзүүлнэ.

Ирэх онд зэсийн баяжмал дахь алтны агууламж сайжирч, түүхий нефтийн экспорт нэмэгдэхийн зэрэгцээ нүүрс, төмрийн хүдрийн экспорт өндөр түвшинд хадгалагдаж, нийт эрэлтэд цэвэр экспортын үзүүлэх сөрөг нөлөө буурахаар байна.

#### Хүснэгт 2.2 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2023	2024*	2025*
		Төсөөлөл	
ДНБ-ий өсөлт	7.2	5.5	7.3
Дотоод эрэлт	5.4	15.5	10.3
Цэвэр экспорт	1.8	-10.0	-3.0

Эх сурвалж: Монголбанк

<sup>6</sup> Үйлдвэрлэлийн хүчин зүйлс хэвийн ашиглалттай байх үеийн үйлдвэрлэл. Потенциал үйлдвэрлэл нь статистик

### Эдийн засгийн цаашидын төлөвт нөлөөлж болзошгүй тодорхой бус байдал


Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
БНХАУ-ын эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж, гангийн зах зээлд сөрөг хүлээлт давамгайлж байна. Энэ нь манай улсын гадаад эрэлт, экспортын бүтээгдэхүүний үнэд сөргөөр нөлөөлж, гадаад валютын орох урсгалыг муутгах эрсдэлтэй. Энэ тохиолдолд төсвийн орлого төлөвлөгөөнөөс буурах, эдийн засгийн өсөлт муудах эрсдэлтэй.	Дунд	Өндөр (сөрөг)
Төсвийн тэлэх бодлого ирэх онд үргэлжлэхээр байгаа нь төлбөрийн тэнцэлд томоохон дарамт учруулж болзошгүй байна. Ялангуяа, ирэх оны төсвийн төсөөлөлд авч үзсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлж чадахгүй тохиолдолд төлбөрийн тэнцэлд ирэх дарамт нэмэгдэж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэр алдагдах нөхцөл байдал үүсэж болзошгүй.	Өндөр	Өндөр (сөрөг)
Геополитикийн зөрчилтэй холбоотойгоор гадаад орчны эрсдэл, тодорхой бус байдал буурахгүй, үргэлжилсэн хэвээр байна	Бага	Бага (сөрөг)

### Потенциал үйлдвэрлэл<sup>6</sup>

Олон хувьсагчийн Калман фильтр, нэг хувьсагчийн НР фильтр, Үйлдвэрлэлийн функцийн арга зэрэг ялгаатай аргуудаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн дундаж өсөлт тайлант улиралд 6 орчим хувьд буюу цар тахлын өмнөх үеийн түвшинтэй ойролцоо байна (Зураг 2.2).

мэдээллээс шууд тооцогдохгүй тул эдийн засгийн тэнцвэрийн шинжилгээнээс тооцон гаргадаг.

Зураг 2.2 Потенциал үйлдвэрлэлийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк

Үйлдвэрлэлийн функцын аргачлалаар тооцсон потенциал үйлдвэрлэлийн өсөлтөд капитал хуримтлал, хөдөлмөр зэрэг үйлдвэрлэлийн орцууд эерэг нөлөөтэй байна. Тухайлбал, 2022 оноос эхлэн тайлант улирал хүртэлх хугацаанд хөдөлмөрийн орц нэмэгдэх хандлагатай бол капитал хуримтлал төдийлөн өөрчлөлтгүй байна.

### Үйлдвэрлэлийн зөрүү<sup>7</sup>

Гадаад дараалсан шокуудын нөлөөгөөр дотоод эдийн засгийн идэвхжил хумигдаж, үйлдвэрлэлийн зөрүү 2020-2022 онд сөрөг түвшинд хадгалагдсан. Харин 2023 онд уул уурхайн салбар сэргэж, дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнээс шалтгаалан нийт үйлдвэрлэлийн сөрөг зөрүү багаслаа. Уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл 2023 оны сүүлийн хагасаас потенциал түвшнээсээ давж үйлдвэрлэлийн зөрүү 3 улирлын туршид эерэг түвшинд хадгалагдсан ч хөдөө аж ахуйн салбарын агшилтаас шалтгаалан тайлант улиралд сөрөг болж буурлаа. Уул уурхайн салбарын хувьд нүүрсний экспорт өндөр хадгалагдаж, үйлдвэрлэлийн зөрүү эерэг түвшинд хүрлээ (Зураг 2.3).

<sup>7</sup> Үйлдвэрлэлийн зөрүү нь потенциал үйлдвэрлэл болон бодит ДНБ-ий зөрүүгээр тодорхойлогдоно.

Зураг 2.3 Үйлдвэрлэлийн зөрүү<sup>8</sup>

Эх сурвалж: Монголбанк

### 2.2. Эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл

Хоёрдугаар улирлын эдийн засгийн өсөлтийг тоймлон авч үзвэл:


- Эдийн засгийн өсөлт 3.9 хувьд хүрч саарахад хөдөө аж ахуйн салбарын уналт нөлөөллөө;
- Үйлчилгээний салбарын идэвхжил нэмэгдэв.

### Нийт нийлүүлэлт

Нийт үйлдвэрлэл хоёрдугаар улиралд 3.9 хувиар, оны эхний хагас жилд 5.6 хувиар өслөө. Уул уурхайн үйлдвэрлэл, тээврийн салбарын өсөлт өндөр хадгалагдсан нь нийт өсөлтийн тал хувийг бүрдүүлэв. Мөн хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжилийг даган татварын орлого бүрдүүлэлт сайн байлаа. Харин цаг уурын таагүй нөхцөл байдлаас үүдэн малын хорогдол өндөр байснаар хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл огцом унав.

<sup>8</sup> Макро эдийн засгийн загварт суурилсан тооцоолол.

Зураг 2.4 Нийт үйлдвэрлэлийн өсөлт, улирлаар




\* - Худалдаа, мэдээлэл холбоо, бусад үйлчилгээ

Эх сурвалж: УСХ

Нийт үйлдвэрлэлийн II улирлын өсөлтийг салбаруудаар авч үзвэл (Зураг 2.4):

Уул уурхайн олборлолт II улиралд 17.5 хувиар тэлж, эдийн засгийн өсөлтийн 1.8 нэгж хувийг бүрдүүллээ. Нүүрсний олборлолтын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 50 орчим хувиар давж 25.8 сая тонн хүрснээс гадна төмрийн хүдрийн баяжмалын олборлолт 40 гаран хувиар нэмэгдсэн нь уул уурхайн салбарын өсөлтийг бүрдүүллээ (Зураг 2.5). Мөн уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг даган тээврийн салбарын өсөлт өндөр хэвээр байна. Тээврийн салбарын нэмэгдсэн өртөг хоёрдугаар улиралд жилийн 22.7 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтөд 0.8 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэв.


Зураг 2.5 Нүүрсний эрэлт өндөр байна



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Бусад үйлчилгээний салбарын эрч II улиралд нэмэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 10.7 хувиар тэлснээр тайлант улирлын эдийн засгийн өсөлтийн 2.7 нэгж хувийг бүрдүүлэв. Тухайлбал, байр, орон сууц, нийтийн хоол, урлаг үзвэрийн үйлчилгээний салбарын үйлдвэрлэл өндөр өссөн байна.

Зураг 2.6 Үйлчилгээний салбарын идэвхжил



Эх сурвалж: УСХ


Харин зудын хүндрэлээс үүдэн хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 27.0 хувиар унаж, нийт өсөлтөд 5.8 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв. Үүнд, том малын зүй бус хорогдол 2010 оноос хойших хамгийн муу түвшинд хүрч, оны эхнээс нийт малын 12.5 хувь буюу 8.1 сая толгой мал хорогдсон нь нөлөөлсөн байна.

Ийнхүү хөдөө аж ахуйгаас бусад салбарын идэвхжил өндөр байснаар татварын орлого бүрдүүлэлт сайн байж, бүтээгдэхүүний цэвэр татварын орлого жилийн 16.4 хувиар нэмэгдэж, II улирлын эдийн засгийн өсөлтийн 2.5 нэгж хувийг дангаараа бүрдүүлжээ.

### Нийт эрэлт

Нийт эрэлт 2024 оны эхний хагас жилд 5.7 хувь, II улиралд 3.9 хувиар өслөө. Энэхүү өсөлтийг 1) өрхийн хэрэглээ, 2) төрийн байгууллагын хэрэглээ голлон бүрдүүлж байна (Зураг 2.7).

Зураг 2.7 Өрхийн хэрэглээ болон төрийн байгууллагын хэрэглээ нийт эрэлтийг тэлж байна




Эх сурвалж: YCX

Өрхийн хэрэглээ 2024 оны 2-р улиралд 16.9 хувиар тэлж, нийт өсөлтийн 11.6 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Өрхийн бодит орлого 2-р улиралд жилийн 18.8 хувиар өссөний зэрэгцээ инфляц саарч байгаа нь өрхийн хэрэглээг дэмжиж байна (Зураг 2.8).

Өрхийн хэрэглээг бүтцээр нь задалбал хүнсний хэрэглээ төдийлөн нэмэгдээгүй, харин хүнсний бус хэрэглээ өрхийн хэрэглээний өсөлтийн голлох хэсэг нь байна. Тодруулбал, хүнсний бус хэрэглээ сүүлийн 11 улирал дараалан өсөлттэй байж тайлант улиралд 30 хувиар өсжээ.

Зураг 2.8 Өрхийн хэрэглээний өсөлт өндөр байна




<sup>9</sup> Засгийн газрын нийт бараа үйлчилгээний зардлыг тухайн улирлын засгийн газрын хэрэглээний дефляторыг ашиглан бодит болгон тооцов.

Эх сурвалж: YCX, Судлаачийн тооцоолол

Төрийн байгууллагын хэрэглээ 2024 оны 2-р улиралд өмнөх жилээс 43.7 хувиар нэмэгдэж, өсөлтийн 9.4 нэгж хувийг бүрдүүлэв. Тухайлбал, бараа үйлчилгээний зардал тайлант улиралд бодит<sup>9</sup> дүнгээр жилийн 123.9 хувиар өсжээ.

Хөрөнгийн нийт хуримтлал 2024 оны 2-р улиралд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.2 хувиар өсөж, нийт эрэлтийн өсөлтөд 2.6 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ. Үүнд, малын хорогдлын улмаас үндсэн хөрөнгийн хуримтлал өмнөх жилээс буурч тайлант улиралд нийт эрэлтэд 4.9 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Харин нийт бараа материал, уул уурхайн бүтээгдэхүүний үлдэгдэл (овоолго) их байгаа нь материаллаг эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлж нийт эрэлтэд 7.5 нэгж хувийн нэмэгдүүлэх нөлөөг үзүүллээ.

Зураг 2.9 Нүүрсний экспорт нэмэгдэж байна



Эх сурвалж: ГЕГ

Цэвэр экспорт тайлант улиралд нийт өсөлтөд 19.7 хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна. Нийт экспорт тайлант улиралд 5.0 хувиар өсөж нийт эрэлтийг 3.4 нэгж хувиар дэмжсэн хэдий ч импорт 2024 оны 2-р улиралд үргэлжлэн тэлж өсөлтөд 23.1 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна.

### 3. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

#### 3.1. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн насны хүн амын тоо тайлант улиралд 2'298 мянгад хүрлээ. Үүнийг гол бүрэлдэхүүн хэсгүүдээр өмнөх оны мөн үетэй харьцуулбал ажиллах хүч өсөж, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо буурсан байна (Хүснэгт 3.1).


Хүснэгт 3.1 Хөдөлмөрийн насны хүн амын шилжилт хөдөлгөөн

мянган хүн	2019Q2	2023Q2	2024Q1	2024Q2
<b>Хөдөлмөрийн насны хүн ам</b>	<b>2126.8</b>	<b>2272.5</b>	<b>2298.0</b>	<b>2297.9</b>
<b>Ажиллах хүч</b>	<b>1293.3</b>	<b>1355.3</b>	<b>1404.4</b>	<b>1429.4</b>
Ажиллагчид	1162.2	1279.1	1332.6	1347.1
Бүрэн хөдөлмөр эрхлэлт	1144.4	1272.1	1323.1	1339.9
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хө	17.8	7.0	9.5	7.2
Ажилгүй хүн	131.1	76.2	71.8	82.3
<b>Ажиллах хүчнээс гадуурх хүн ам</b>	<b>833.5</b>	<b>917.2</b>	<b>893.7</b>	<b>868.5</b>
Боломжит ажиллах хүч	63.1	28.0	36.3	27.8
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	770.4	889.1	857.4	840.7

Эх сурвалж: ҮСХ

Ажилгүй хүмүүсийн тоо өмнөх улирлаас 14.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 8 хувиар өсөж 82.3 мянган хүнд хүрэв. Ийнхүү 2023 оны 4-р улиралд статистик бүртгэж эхэлснээс хойших хамгийн доод түвшин буюу 3.9 хувьд хүрээд байсан ажилгүйдлийн түвшин тайлант улиралд 5.8 хувьд хүрч өсжээ (Зураг 3.2).


Зураг 3.1 Хөдөлмөрийн насны хүн амын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: ҮСХ

Харин ажиллах хүчний оролцооны түвшин тайлант II улиралд өмнөх улирлаас 1.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 нэгж хувиар өсөж 62.2 хувьд хүрлээ.

Зураг 3.2 Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд




Эх сурвалж: ҮСХ

#### Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Нийт ажиллагчдын тоо тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 68 (5.3%) мянган хүнээр өссөн байна. Тодруулбал, уул уурхай, барилга, худалдаа, тээвэр болон бусад үйлчилгээний салбарт ажиллагчдын тоо нэмэгдэж, харин хөдөө аж ахуй болон боловсруулах салбарт ажиллагчид буурчээ (Зураг 3.3).

Ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж байгаа хэдий ч нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо буурсан байна. 2024 оны 6-р сарын байдлаар нийгмийн даатгалд хамрагдагчдын тоо өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар буураад байна. Үүнд, албан журмаар даатгуулагчдын тоо 10.6 хувиар, сайн дураар даатгуулагчдын тоо 27.1 хувиар тус тус буурчээ.

Зураг 3.3 Ажиллагчдын тооны жилийн өөрчлөлт, салбараар



Эх сурвалж: ҮСХ

### Цалин, өрхийн орлого

Улсын дундаж нэрлэсэн цалин 2024 оны 2-р улиралд жилийн 30.4 хувиар өссөн бол медиан цалин 42.1 хувиар өслөө. Ингэснээр дундаж цалин 2465 мянган төгрөг, медиан цалин 2027 мянган төгрөгтэй тус тус тэнцэж байна. Цалин ийнхүү нэмэгдсэн нь өрхийн орлогыг өсгөв. Сүүлийн 2 жилд нэрлэсэн цалин өндөр өсөж, инфляц буурах хандлагатай байгаагаас шалтгаалж бодит цалингийн өсөлт эрчимжиж, тайлант улиралд жилийн 23.7 хувиар өслөө (Зураг 3.4).

Зураг 3.4 Цалингийн болон өрхийн орлогын өсөлт




Эдийн засгийн голлох салбаруудаар авч үзвэл төрийн удирдлага (57%), эрчим хүч (53%), боловсрол (48%), эрүүл мэнд (37%) хөдөө аж ахуй (34%), тээвэр ба агуулах (30%)-н салбарт ажиллагчдын дундаж нэрлэсэн цалин хамгийн өндөр өсжээ. Харин уул уурхай (10%), худалдаа (22%), боловсруулах (23%), барилга (26%)-ын салбарт алба хаагчдын цалингийн өсөлт харьцангуй бага байна.

### Нэгж хөдөлмөрийн зардал

Нэгж хөдөлмөрийн зардал<sup>10</sup> сүүлийн 2 жилд өндөр өсөлттэй байна. Тодруулбал, цалингийн өсөлт бүтээмжийн өсөлтөөс үлэмж өндөр байгаа нь цаашид

үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлж, улмаар үнэ өсөх гол шалтгаан болж болзошгүй юм (Зураг 3.5).

Зураг 3.5 Нэгж хөдөлмөрийн дундаж зардлын жилийн өөрчлөлт, бүрэлдэхүүнээр



## 3.2. Мөнгө, санхүүгийн зах зээл

### 3.2.1. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд


Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд эрчимжсэн бол 7, 8 дугаар саруудад саарав. Харин зээлийн өсөлт үргэлжлэн эрчимжиж байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 31.9 хувьд хүрч нэмэгдэхэд зээлийн өсөлт, тэр дундаа бизнес болон ипотекийн зээлийн өсөлт эрчимжсэн нь нөлөөллөө. Тодруулбал, зээлийн өсөлт 2024 оны 3 дугаар сард мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд 17.4 нэгж хувийн нөлөө үзүүлж байсан бол 6 дугаар сард 24.7 нэгж хувийн нөлөө үзүүлэв. Харин сүүлийн саруудад төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотой банкны системийн гадаад цэвэр актив (ГЦА)-ын өсөлт саарч, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 8 дугаар сард 27.3 хувьд хүрлээ. Нөгөө талаас Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн хэвээр байна (Зураг 3.6).

<sup>10</sup> Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалин.




Зураг 3.6 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Эх сурвалж: Монголбанк

Ийнхүү мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 27.3 хувьд хүрэхэд зээл 25.8 нэгж хувь, ГЦА 10.7 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол ЗГЦЗ -6.2 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүллээ.


Зураг 3.7 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал



Эх сурвалж: Монголбанк

Эх үүсвэр талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг төгрөгийн эх үүсвэр голлон бүрдүүлсэн хэвээр байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 29.4 нэгж хувийг төгрөгийн харилцах, хадгаламж бүрдүүлж байгаа бол гадаад валютын харилцах, хадгаламж -2.4 нэгж хувийн нөлөө үзүүлжээ.


Зураг 3.8 Банкуудын зээл болон эх үүсвэрийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

Улмаар банкны системийн эх үүсвэрийн долларжилт 2024 оны 8 дугаар сард 23.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 8.8 нэгж хувиар буурав. Ханшийн нөлөөг хасаж тооцвол эх үүсвэрийн долларжилт 19.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.2 нэгж хувиар буурчээ (Зураг 3.8).

Зураг 3.9 Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн




Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн өсөлт 2024 оны 8 дугаар сард 33.6 хувьд хүрч, үргэлжлэн эрчимжлээ (Зураг 3.9). Зээлийн зориулалтаар нь харвал, энэ онд Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдаж, Хуримтлалын сангийн эх үүсвэрээр ипотекийн зээлийг санхүүжүүлэх болсноор санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, нийт

ипотекийн зээлийн<sup>11</sup> өсөлт эрчимжих хандлагатай байна<sup>12</sup>. Энэ оны 4 дүгээр сард төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр нэмэгдэн хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт өндөр түвшинд хадгалагдаж байна<sup>13</sup>. Түүнчлэн, бизнесийн зээлийн өсөлт 27.1 хувьд хүрч нэмэгдсэн бөгөөд эдийн засгийн салбараар авч үзвэл, худалдаа, үйлчилгээ, боловсруулах, уул уурхайн салбарын зээл бизнесийн зээлийн өсөлтийг голлон тэтгэж байна (Зураг 3.10).

Валютын төрлөөр нь авч үзвэл банкны системийн төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 33.1 хувиар, гадаад валютын зээлийн үлдэгдэл 43.2 хувиар нэмэгдэж, зээлийн долларжилт сүүлийн хоёр жилд 6 хувийн орчимд тогтвортой байна (Зураг 3.8).

Зураг 3.10 Банкны системийн чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар




Банкны системийн зээлийн чанар сайжирч байна. Тухайлбал, чанаргүй зээлийн үлдэгдэл 2024 оны 8 дугаар сард 2.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 243 тэрбум төгрөгөөр буюу 11.0 хувиар буурлаа. Үүнд, дийлэнх салбарын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс буурсан бөгөөд уул уурхай, худалдаа, үйлчилгээний салбарын чанаргүй зээл

<sup>11</sup> Ипотекийн зээлээр баталгаажуулсан бонд оруулж тооцсон.

<sup>12</sup> 2024 оны 8 дугаар сард 26.3 хувьд хүрэв.

голлон буурчээ. Нөгөө талаас хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл болон тээврийн салбарын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн байна. Ийнхүү чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь үргэлжлэн буурч 5.8 хувьд хүрсэн<sup>14</sup> нь 2015 оноос хойших хамгийн бага түвшин болж байна (Зураг 3.10).

Зураг 3.11 Банкны системийн анхаарал хандуулах зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Банкны системийн анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл мөн буурлаа (Зураг 3.14). Тодруулбал, 2024 оны 8 дугаар сарын байдлаар анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 96 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар буурч, 1.3 их наяд төгрөгт хүрээд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдаа, барилга, уул уурхайн салбарын анхаарал хандуулах зээл голлон буурсан бол нөгөө талаас хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээл болон үйлчилгээний салбарын анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл өссөн байна. Улмаар анхаарал хандуулах зээл нийт зээлийн багцын 3.8 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар бага дүн юм.

<sup>13</sup> 2024 оны 8 дугаар сард 37.8 хувьд хүрэв.


<sup>14</sup> Өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар бага дүн юм.

### 3.2.2. Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2024 оны 5 дугаар сарын ээлжит бус хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах, 9 дүгээр сарын ээлжит хурлаар мөн 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа. Бодлогын хүү буурсныг дагаад банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2024 оны 8 дугаар сард өмнөх улирлаас<sup>15</sup> 1.6 нэгж хувиар буурч 11.0 хувьд хүрлээ.

Тодруулбал, ТБҮЦ барьцаалсан репо хэлцлийн хүү 1.9 нэгж хувиар буурч 11.0 хувьд, ТБҮЦ-ны шууд хэлцлийн хүү 1.6 нэгж хувиар буурч 11.0 хувьд, банк хоорондын захын хадгаламжийн хүү 1.1 нэгж хувиар буурч 11.3 хувьд, банк хоорондын захын овернайт зээлийн хүү 1.0 нэгж хувиар буурч 11.0 хувьд тус тус хүрсэн байна (Зураг 3.12).

Зураг 3.12 БХЗ-ын хэлцлийн хүү, хувь




Эх сурвалж: Монголбанк

Банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү энэ оны 8 дугаар сард өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар буурч 11.5 хувьд хүрсэн байгаа бол шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 0.3 нэгж хувиар буурч 16.5 хувьд тус тус хүрлээ. Үүнээс

хөнгөлөлттэй зээлийг<sup>16</sup> хасаж тооцсон шинээр олгосон зээлийн хүү тайлант сард 17.0 хувьд буюу өмнөх улирлын орчимд байна. Улмаар зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар нэмэгдэж, тайлант сард 5.0 хувьд хүрлээ (Зураг 3.13).

Зураг 3.13 Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү, төгрөг



\* Нийт зээлийн хүүнээс тооцсон

Эх сурвалж: Монголбанк


Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү өмнөх улирлаас буурсан бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өслөө. Тодруулбал, шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү энэ оны 8 дугаар сард 9.5 хувьд хүрч өмнөх улирлаас 1.2 нэгж хувиар буурсан бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү 3.5 хувьд хүрч өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар өссөн байна. Улмаар гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх улирлаас 1.5 нэгж хувиар буурч 6.0 хувьд хүрлээ (Зураг 3.14).

<sup>15</sup> 2024 оны 3 дугаар сартай харьцуулахад

<sup>16</sup> Банкуудын зах зээлийн хүүгээс доогуур буюу Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөтөлбөр,

төлөвлөгөөний хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлтэй олгосон зээл

Зураг 3.14. Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү, гадаад валют



Эх сурвалж: Монголбанк

### 3.2.3 Валютын ханш

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сүүлийн 4 сарын турш 3380 төгрөгийн орчимд тогтвортой хадгалагдлаа. 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3381 төгрөгтэй тэнцэж байгаа нь оны эхнээс 1.0 хувиар чангарсан үзүүлэлт болж байна (Зураг 3.15).

Нүүрсний экспорт энэ онд өндөр хэвээр хадгалагдаж, экспортын орлого сайн байгаа нь гадаад валютын орох урсгалыг дэмжиж байна. Гадаад валютын цэвэр урсгал эхний 8 сард 1.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 530 сая ам.доллараар өссөн нь төгрөгийн ханшид ирэх дарамтыг бууруулж, ханш тогтворжих нөлөөг үзүүлж байна.


Зураг 3.15 Төгрөгийн ам.доллартой харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн ханш (NEER) энэ оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар чангарлаа (Зураг 3.16). Төгрөгийн ханш дийлэнх худалдааны түнш орнуудын валютуудын эсрэг чангарснаар нэрлэсэн ханш ийнхүү чанга тогтож байна. Тухайлбал, өмнөх улирлуудад голлох валютуудын эсрэг чангарч байсан эрчээ хадгалж, 7 дугаар сарын байдлаар төгрөгийн ханш юанийн эсрэг 3.1 хувиар, еврогийн эсрэг 3.9 хувиар тус тус чангарав. Харин рублийн эсрэг 4.3 хувиар суларсан үзүүлэлттэй байна.


Зураг 3.16 Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханш



Эх сурвалж: Монголбанк

Нэрлэсэн ханш ийнхүү чанга тогтож байгаагаас гадна гадаад үнэ буурч, бодит ханш энэ оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар чанга тогтлоо.


Зураг 3.17 Төгрөгийн гадаад валютуудтай харьцах ханшийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн харьцангуй өгөөж энэ оны 8 дугаар сарын байдлаар 0.66 хувьд хүрлээ. Ийнхүү төгрөгийн харьцангуй өгөөж сүүлийн жил гаруйн хугацаанд эерэг дүнтэй хадгалагдахад төгрөгийн ханш ам.долларын эсрэг тогтвортой байж, төгрөгийн хадгаламжийн хүү өндөр байгаа нь голлон нөлөөлжээ. Төгрөгийн өгөөж ийнхүү эерэг байгаа нь төгрөгөөр хадгалах сонирхлыг нэмэгдүүлж, төгрөгийн хадгаламж энэ оны 8 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар өссөн бол гадаад валютын хадгаламж 12.7 хувиар буурсан дүнтэй байна (Зураг 3.18).

Зураг 3.18 Төгрөгийн харьцангуй өгөөж



Эх сурвалж: Монголбанк


### 3.2.4. Хөрөнгийн зах зээл

Тайлант улиралд орон сууцны үнэ өсөж, хөрөнгийн зах зээлийн идэвхжил суларлаа.

#### Орон сууцны зах зээл

Тайлант улиралд орон сууцны үнэ өмнөх улирлаас нэмэгдлээ. Тодруулбал, ҮСХ-ны мэдээгээр орон сууцны үнэ энэ оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 2.4 хувиар өссөн ба үүнээс шинэ орон сууцны үнэ 0.8 хувиар, хуучин орон сууцны үнэ 3.1 хувиар тус тус өссөн байна. Харин Тэнхлэг Зууч компанийн мэдээллээр орон сууцны үнэ өмнөх улирлаас 1.5 хувиар өсөж, үүнд хуучин орон сууцны үнэ 3.2 хувиар өссөн нь гол нөлөөг үзүүлжээ.

Зураг 3.19 Орон сууцны үнэ, түрээсийн үнийн жилийн өсөлт




Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

Цалин, тэтгэвэр энэ онд үргэлжлэн нэмэгдэж, өрхийн орлого сүүлийн улирлуудад тэлж байгаагаас гадна орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, орон

сууцны эрэлтийг дэмжиж байна.<sup>17</sup> Түүнчлэн, тайлант улиралд барилгын өртөг өмнөх улирлаас 5.6 хувиар өслөө. Үүнд, цалингийн зардал өмнөх улирлаас 13.2 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна. Харин төгрөгийн ханш тогтвортой хадгалагдаж, гадаад инфляц буурч байгаагаас шалтгаалан бараа, материалын үнэ саарч, нийт барилгын өртөгт сүүлийн 3 улирал бууруулах нөлөө үзүүллээ. Ийнхүү нэг талаас орон сууцны эрэлт нэмэгдсэн, нөгөө талаас цалингийн зардал өссөн нөлөөгөөр барилгын өртгийн өсөлт нэмэгдэж байгаа нь орон сууцны үнэ өсөхөд нөлөөлж байна.

**Зураг 3.20 Орон сууцны барилгын өртгийн жилийн өсөлт**




Өрхийн орлогын өсөлт орон сууцны үнийн өсөлтөөс өндөр байснаар үнэ-орлогын харьцаа өмнөх улирлаас бага зэрэг буурлаа. Үнэ-орлогын харьцаа сүүлийн 6 улирал дараалан нам түвшин хадгалагдаж байгаа нь өрхийн орон сууц худалдан авах чадвар сайжирч буйг харуулж байна.

Түрээсийн үнэ сүүлийн хоёр улирал дараалан өсөх хандлагатай болж, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх улирлаас

5.0 хувиар өслөө. Түрээсийн үнэ ийнхүү нэмэгдэж, үнийн өсөлт нь орон сууцны үнийн өсөлтөөс өндөр байгаагаас шалтгаалан үнэ-түрээсийн харьцаа өмнөх улирлаас буурсан байна. Энэхүү үзүүлэлт сүүлийн улирлуудад харьцангуй тогтвортой байгаа нь орон сууцны зах зээлд үнэ хэт өсөх, хөөсрөх эрсдэл бага байгааг харуулж байна.

**Зураг 3.21 Үнэ-орлогын болон үнэ-түрээсийн харьцаа**



Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч


**Хөрөнгийн зах зээл**

Тайлант улиралд зах зээлийн нийт үнэлгээ өмнөх улирлаас 3.6 хувиар буурсан бол ТОП-20 индекс өмнөх улирлын орчимд хадгалагдлаа.


ТОП-20 индексийн өөрчлөлтийг компаниудаар авч үзвэл Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Инвескор, АПУ зэрэг компаниудын ашиг тайлант улиралд буурч, хувьцааны үнэ саарсан байгаа бол Түмэн шувуут, Тавантолгой, Сүү зэрэг компаниудын ашигт ажиллагаа сайжирч, хувьцааны үнэ өссөнөөр ТОП-20 индекс өмнөх улирлын орчимд тогтвортой хадгалагдлаа.

<sup>17</sup> Тайлант улиралд нийт 953.1 тэрбум төгрөгийн ипотекийн санхүүжилт олгосон бөгөөд энэ нь 2023 оны улирлын дундаж түвшнээс 90 хувиар өндөр дүн юм.

Зураг 3.22 Хөрөнгийн захын үзүүлэлтүүд



Хөрөнгийн зах дээр энэ оны 2 дугаар улиралд 609.1 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн ба үүний 500 тэрбум төгрөг нь Улаанбаатар бондыг арилжаалсантай холбоотой байна (Зураг 3.23). Уг бондын арилжааг хасаж тооцвол үнэт цаасны арилжаа өмнөх улирлаас 40 гаруй хувиар буурч, арилжааны идэвх суларсан байна.

Зураг 3.23 Нийт арилжаа, бүтцээр<sup>18</sup>

Тодруулбал, хувьцааны арилжааны хувьд анхдагч зах дээр Эм Жи Эл Акуа компанийн 15.2 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 29.5 тэрбум төгрөгийн арилжаа тус тус

хийгдэж, нийт хувьцааны арилжаа өмнөх улирлаас 2 дахин буурлаа.

Компанийн бондын арилжаа мөн өмнөх улирлаас буурлаа. Анхдагч зах зээл дээр “Ашид Капитал ББСБ” 20.0 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн бол хоёрдогч зах зээлд нийт 2.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт дүнгээр компанийн бондын арилжаа өмнөх улирлаас 50 орчим хувиар буурлаа.

Харин хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа өмнөх улирлаас 11.0 тэрбум төгрөгөөр буюу 70 орчим хувиар нэмэгдлээ. Тодруулбал, ХБҮЦ-ны анхдагч зах зээлд “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК 20 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж арилжсан бол хоёрдогч зах зээлд 7.7 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Хөрөнгө оруулалтын сангийн нийт 1.8 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, арилжааны идэвх өмнөх улиралтай харьцуулахад 600 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

### 3.3. Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

**Нэгдсэн төсөв:** 2024 оны эхний 8 сард төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 29.3 хувиар өндөр төвлөрч, 18.9 их наяд төгрөгт хүрсэн бол зардал 35.4 хувиар өссөн байна. Ийнхүү тэнцвэржүүлсэн тэнцэл эхний 8 сарын байдлаар 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарлаа (Хүснэгт 3.2).

### Тэнцвэржүүлсэн орлого 2024 онд:

Орлогын бүх дэд бүлгүүд эдийн засгийн идэвхжилийг даган өмнөх оноос эрчтэй өссөн хэвээр байна. Тодруулбал, уул уурхайн салбарын идэвхжилийн улмаас тухайн салбарын компаниудын орлого ихсэж, ААНОАТ-ын орлого эхний 8 сард

<sup>18</sup> Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ), Хөрөнгө оруулалтын сан (ХОС)


өмнөх оноос 60.6 хувиар буюу 1.7 их наяд төгрөгөөр нэмэгдсэн бол НӨАТ өмнөх оноос 1.0 их наяд төгрөг буюу 29.2 хувиар өслөө.

**Хүснэгт 3.2 Төсвийн үндсэн үзүүлэлтүүд**

Их наяд төгрөг	2024		2024.M8	
	Бат.	Тод.	Гүй.	Гүй.%
<b>Нийт орлого</b>	<b>27.7</b>	<b>30.6</b>	<b>19.9</b>	102.1
<b>Сангийн орлого</b>	<b>1.9</b>	<b>1.8</b>	<b>1.0</b>	120.8
<b>Тэнцвэржүүлсэн орлого</b>	<b>25.9</b>	<b>28.9</b>	<b>18.9</b>	101.3
Татварын орлого	24	26.9	17.7	101.7
Татварын бус орлого	1.9	1.9	1.1	96.2
<b>Нийт зардал</b>	<b>27.4</b>	<b>30.5</b>	<b>17.3</b>	79.8
Анхдагч зардал	26.2	29.3	16.4	78.6
Хүүний зардал	1.2	1.2	0.9	84.9
<b>Нийт тэнцэл</b>	<b>0.4</b>	<b>0.1</b>	<b>2.6</b>	
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	0.5%	0.2%	3.2%	
<b>Тэнцвэржүүлсэн тэнцэл</b>	<b>-1.5</b>	<b>0.8</b>	<b>1.6</b>	
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-2.0%	-2.0%	2.0%	
<b>Анхдагч тэнцэл</b>	<b>-0.3</b>	<b>-0.4</b>	<b>2.5</b>	
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-0.4%	0.5%	3.1%	

Эх сурвалж: Сангийн яам

**Зураг 3.24 Төсвийн орлогын бүтэц**




Эх сурвалж: Сангийн яам

**Нийт зардал, цэвэр зээл:** Эхний 8 сарын төсвийн зардал оны мөн үеэс 35.4 хувиар буюу 4.7 их наяд төгрөгөөр өндөр байв (Хүснэгт 3.2). Үүнээс урсгал зардал 3.4 их наяд төгрөгөөр нэмэгдсэний 2.6 их наяд төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Үүнд цалингийн зардал 1.9 их

наяд орчим төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

**Зураг 3.25 Төсвийн зардлын бүтэц**



Эх сурвалж: Сангийн яам

**Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр:** Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр 2024 оны 2-р улирлын байдлаар 29.8 их наяд төгрөг буюу нийт нэрлэсэн ДНБ-ий 33.7 хувь байгаа нь хуульд<sup>19</sup> заасан хязгаарыг хангаж байна (Хүснэгт 3.3).

**Хүснэгт 3.3 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр**

Төрөл	2022		2023		2024. II		2024*	
	тэрбум төгрөг	Гүй.	Гүй.	Гүй.	Бат.	Тод	Бат.	Тод
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	27679	26643	29767	39276	31449			
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	52.4	37.8	33.7	60.0	39.7			
<b>Өрийн хязгаар</b>	<b>70.0</b>	<b>65.0</b>	<b>60.0</b>	<b>60.0</b>	<b>60.0</b>			
Зээлийн үйлчилгээний төлбөр	816	1132	4018	1174	1174			
<i>Төсвийн орлогод эзлэх хувь</i>	4.7	4.9	5.5	4.5	4.1			
Төсвийн тэнцэл	-1032	785	1627	-1833	-1615			
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-1.9	1.1	1.8	-2.0	-2.0			

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

<sup>19</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2023 онд 65, 2024 онд 60 хувиас хэтрүүлэхгүй байхаар заажээ.



## 4. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

### 4.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл

**Гадаад эрэлт:** Дэлхийн эдийн засгийн өсөлт олон улсын байгууллагуудын дундаж төсөөллөөр өмнөх улирлаас төдийлөн өөрчлөгдөөгүй буюу 2024 онд 3.1 хувь, дараа онд 3.2 хувь байх төлөвтэй.

Зураг 4.1 Улс орнуудын өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Блүмберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

**БНХАУ-ын өсөлт** 2024 оны 2-р улиралд 4.7 хувьтай гарлаа. Эхний хагасын өсөлтийг засгийн газрын хөрөнгө оруулалт, экспортын өсөлт голлон тайлбарлаж байна. БНХАУ-ын зүгээс хэрэгжүүлж буй үл хөдлөхийн салбараа дэмжсэн бодлого үр дүн муутайн зэрэгцээ дотоодын эрэлт сэргэхгүй байгаа нь 2-р улирлын гүйцэтгэл төсөөлөлд хүрээгүйн шалтгаан болов. Иймээс шинжээчид тус улс энэ оны эдийн засгийн 5 хувийн өсөлтийн зорилтдоо хүрэхэд хүндрэлтэй байгааг онцолж байна. Одоогийн төсөөллөөр БНХАУ-ын өсөлт энэ онд 4.8 хувь байх бол 2025 онд 4.3 хувьд хүрэх төсөөлөлтэй.

**АНУ-ын эдийн засаг** 2024 оны 2-р улиралд жилийн 3.1 хувиар өсөв. Хэрэглээ, хөрөнгө оруулалт өсөлтөд эергээр нөлөөлсөн бол цэвэр экспорт өсөлтийг сааруулах чиглэлд нөлөөлжээ. Шинэчилсэн төсөөллөөр энэ


оны өсөлт 2.3 хувь, 2025 онд 1.8 хувь буюу өмнөх төсөөллийн орчимд байна. Түүнчлэн, энэ оны 11-р сард болох Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн цаашид тус улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлэх талаар шинжээчид онцоллоо.

**Евро бүсийн эдийн засаг** энэ оны 2-р улиралд жилийн 0.6 хувиар өсөв. Оны эхний хагаст үйлчилгээний салбарын идэвхжил сайн, гадаад худалдааны ашиг хүлээлтээс давж буй зэрэг нь өсөлтөд эергээр нөлөөллөө. Улмаар 2024 оны өсөлт өмнөх төсөөллөөс 0.1 нэгж хувиар нэмэгдэж 0.7 хувь болсон бол мөнгөний бодлого зөөлөрснөөр ирэх онд өсөлт нэмэгдэж 1.2 хувьд хүрэх төсөөлөлтэй байна.

**ОХУ-ын эдийн засаг** 2024 оны 2-р улиралд шинжээчдийн хүлээлтээс давж 4.0 хувиар өсөв. Улмаар энэ оны өсөлтийн төсөөлөл 0.6 нэгж хувиар нэмэгдэж 3.4 хувьд хүрэх, 2025 онд 1.6 хувь байх тооцоололтой. Ирэх онуудад мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр өсөлтийн түвшин буурах төлөвтэй.

**Гадаад инфляц:** Дэлхийн ихэнх оронд инфляцын эрч саарсаар байгаа ч төв банкуудын зорилтот түвшнээс өндөр хэвээр байна.

Зураг 4.2 Улс орнуудын инфляцын төсөөлөл



Эх сурвалж: Блүмберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

АНУ-ын жилийн инфляц 2024 оны 7-р сард 2.9 хувьд хүрч, сүүлийн 5 сар дараалан буурав. Харин Евро бүсийн инфляц 7-р сард 2.6 хувь гарч, сүүлийн 3 сар энэ түвшингийн орчимд тогтвортой байв.

БНХАУ-ын инфляц 7-р сард жилийн 0.5 хувь, оны эхний 7 сарын дундаж инфляц 0.2 хувьтай байв. Түүнчлэн, үйлдвэрлэгчийн үнийн индекс 2022 оны 10-р сараас хойш сүүлийн 22 сар дараалан жилийн өмнөх үеэс буураад байгаа зэрэг нь БНХАУ-ын дотоодын эрэлт сайнгүй байгааг харууллаа.

ОХУ-д инфляц сүүлийн саруудад хурдтай нэмэгдэж, улмаар 7-р сарын байдлаар 9.1 хувьд хүржээ. Цаашид ч төсвийн өндөр зардлаас шалтгаалж инфляц нэмэгдэх дарамттай байна.

**Гадаад хүү:** АНУ-ын инфляц хүлээлтийн дагуу буурч байгаагаас шалтгаалж ХНБ энэ оны 9-р сарын хурлаар бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар бууруулаад байна. Харин Европын төв банкны хувьд 2024 оны 6-р сарын хурлаар бодлогын хүүгээ 0.25 пунктээр бууруулсан бөгөөд энэ ондоо багтаад дахин 1-2 удаа хүү бууруулах хүлээлттэй байна. ОХУ-ын инфляц огцом нэмэгдсэн тул тус улсын төв банк 7-р сарын хурлаар бодлогын хүүгээ 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 18 хувьд хүргээд байна. Түүнчлэн, БНХАУ-ын Ардын банк 7-р сард бодлогын хүүгээ 0.1 нэгж хувиар бууруулсан шийдвэр нь эдийн засгийн өсөлтөө дэмжихэд чиглэсэн байв.

#### 4.2.Экспортын үнийн төлөв

**Зэс:** Зэсийн үнэ 2024 оны 2-р улирлын дунджаар 9877 ам.доллар/тн буюу төсөөллөөс өндөр гүйцэтгэлтэй байв. Зэсийн томоохон уурхайнуудад осол гарах, түр хугацаанд хаагдах зэргээр нийлүүлэлт тасалдсан үед эрэлт өндөр байснаас шалтгаалж энэ оны 5-р сарын дунд үеэр зэсийн үнэ түүхэн өндөр утга болох 11464

ам.доллар/тн-д хүрсэн. Гэхдээ түүнээс хойш үнэ буурах хандлага үргэлжилсээр 8-р сарын эхээр 9000 ам.доллар/тн хүрч, тэр орчимдоо хэлбэлзэж байна. Үүнд, нэг талаас зэсийн олборлолт өсөж, агуулах дахь зэсийн нөөц нэмэгдсэн нь нөлөөлсөн бол нөгөө талаас зэсийн гол хэрэглэгч болох БНХАУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд хүлээлтээс доогуур байж, улмаар зэсийн эрэлт саарсан нөлөө байв. Хэдий тийм ч зэсийн үнэ дараа онд энэ оны дунджийн орчимд байх бөгөөд зэсийн орц өндөртэй цахилгаан автомашины үйлдвэрлэл, нар, салхины сэргээгдэх эрчим хүчтэй холбогдсон төслүүдийн хөрөнгө оруулалт хурдтай нэмэгдэхээр байгаа нь эрэлтэд том нөлөө үзүүлэх төлөвтэй.

**Алт:** Алтны үнэ 2024 оны эхнээс тогтвортой өссөн хандлага хэвээр байна. Геополитикийн хурцадмал байдал үргэлжилсэн хэвээр байгаа нь алтанд хөрөнгө оруулах сонирхлыг өдөөсөөр байна. Үүний зэрэгцээ БНХАУ-ын үл хөдлөх салбар хүндрэлтэй байгаагаас тус улсын хөрөнгө оруулагчид алтанд ихээр хөрөнгө оруулж байна. Улмаар 2024-2025 оны үнийн төсөөлөл өмнөхөөс унци тутамдаа 150 орчим ам.доллороор нэмэгдлээ.

**Коксжих нүүрс:** Коксжих нүүрсний хилийн үнэ 2-р улиралд төсөөллийн орчимд байсан бөгөөд цаашдын төсөөлөл ч мөн өөрчлөлт багатай, үнэ буурах хандлага хэвээр байна. Түүнчлэн, энэ оны сүүлийн улирлаас La Nina үзэгдэл болж Австрали улсад бороо ихтэй байх таамаглалтай байна. Өмнө нь энэ үзэгдлийн үед тус улсын нүүрсний олборлолт, тээвэрлэлт саатаж, улмаар нийлүүлэлт доголдож, үнэд эерэгээр нөлөөлж байсан түүхтэй. Гэвч БНХАУ-ын коксжих нүүрсний импортод Австрали улсын эзлэх жин буурсан тул Австралийн нийлүүлэлт буурсан ч манай улсын


экспортын нүүрсний үнэд төдийлөн эерэг нөлөө үзүүлэхээргүй байна.

**Төмрийн хүдэр:** Төмрийн хүдрийн үнэ 2-р улирлын дунджаар тонн тутамдаа 106 ам.доллар болж өмнөх улирлаас 5.5 хувиар буурав. Цаашдын үнийн төсөөлөл өмнөх төсөөллийн орчимд байгаа бөгөөд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өмнөх онуудаас саарах, үл хөдлөхийн салбарын хүндрэл үргэлжлэх хүлээлт хэвээр байгаа нь төмрийн хүдрийн үнэ буурахад нөлөөллөө.

**Газрын тос:** Брент газрын тосны үнэ 2-р улирлын дунджаар 85.3 ам.доллар/баррель буюу төсөөллийн орчимд байв. Нэг талаас ОПЕК+-ын зүгээс газрын тосны нийлүүлэлтийн хязгаарлалтаа ирэх оныг дуустал сунгасан ч дэлхий нийтээр газрын тосны эрэлт сул байгаа нь үнэ тогтвортой байх нөхцлийг бүрдүүлж байна. Цаашид газрын тосны үнэд АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн дүн, цахилгаан автомашины хэрэглээний өсөлт, Европ болон хөгжиж буй эдийн засгууд дахь газрын тосны эрэлтийн өсөлт саарч буй зэрэг олон хүчин зүйл нөлөөлөх бөгөөд ирэх онуудад үнэ буурах хүлээлт хэвээр байна. Гэвч геополитикийн эрсдэл, түүнд газрын тосны томоохон олборлогчдын оролцоо нэмэгдэх магадлалтай байгаа нь энэхүү төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлэв.

**Худалдааны нөхцөл:** Хэдийгээр 2-р улиралд зэс, алтны үнийн огцом өсөлтөөс шалтгаалж худалдааны нөхцөл төсөөллөөс сайн гарсан ч цаашид өмнөх улирлын төсөөллийн орчимд байхаар байна (Зураг 4.2). Ойрын 2 жилд импортын үнийн өсөлт харьцангуй бага байх бол голлон экспортын үнийн бууралтаас шалтгаалж худалдааны нөхцөл муудах хүлээлт хэвээр байна.

Зураг 4.3 Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

### 4.3.Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2024 оны эхний хагас жилд 57 сая ам.доллар, II улиралд 431 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Тайлант улиралд алдагдалтай гарахад дараах хүчин зүйл голлон нөлөөлөв.

- Нүүрсний экспортын биет хэмжээ үргэлжлэн өсөж байгаа хэдий ч эдийн засгийн идэвхжил, төсвийн зардлын өсөлтөөс шалтгаалан импортын өсөлт эрчтэй нэмэгдэв.
- Монголбанк БНХАУ-ын Ардын банктай хийсэн своп хэлцлийн үндсэн төлбөрөөс 4.5 тэрбум юань буюу 621 сая ам.долларыг төллөө.

Зураг 4.4 Төлбөрийн тэнцэл 2024 оны II улиралд -431 сая ам.долларын алдагдалтай байв.



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийг гол бүрэлдэхүүн хэсгүүдээр дэлгэрүүлж тайлбарлавал:

**Экспортын орлого 2024 оны II улиралд өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өсөв.** Үүний 9.9 нэгж хувийг чулуун нүүрсний экспорт тайлбарлаж байна. Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ тайлант улиралд 21.8 сая тоннд хүрч нэг улирлын түүхэн дээд хэмжээгээ давж, өмнөх оны мөн үеэс 50 хувиар нэмэгдсэн бол үнэ өмнөх жилээс 17%-оор буураад байна. Мөн төмрийн хүдрийн биет хэмжээ өссөн, зэсийн үнэ нэмэгдсэн нь экспортын орлогод эерэг нөлөөтэй байв.

#### Хүснэгт 4.1 Экспортын орлогын өсөлтийг нүүрсний экспорт бүрдүүлсэн хэвээр байна.

сая ам.доллар	2023 II	2024 II	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
<b>Нийт экспорт</b>	<b>3,800</b>	<b>4,227</b>	<b>11.2</b>	<b>11.2</b>
Чулуун нүүрс	2,087	2,462	18.0	9.9
Зэсийн хүдэр, баяжмал	698	816	16.9	3.1
Төмрийн хүдэр, баяжмал	120	148	23.6	0.7
Мөнгөжөөгүй алт	182	142	-21.7	-1.0
Ноолуур	148	169	14.2	0.6
Боловсруулаагүй нефть	87	83	-4.0	-0.1
Мах, махан бүтээгдэхүүн	41	28	-40.2	-0.5
Бусад самар	14	7	-49.5	-0.2
Жонш, лейцит, нефелинт	74	72	-2.2	0.0
Мөнгөний хүдэр, баяжмал	34	44	29.3	0.3
Молебдиний хүдэр, баяжмал	33	26	-22.5	-0.2
Цайрын хүдэр, баяжмал	66	62	-6.6	-0.1
Бусад	211	168	-20.5	-1.1

Эх сурвалж: ГЕГ

**Импортын жилийн өсөлт** үргэлжлэн эрчимжиж, оны II улиралд 27.0 хувьд хүрлээ. Импортын бүхий л дэд бүлгийн өсөлт нэмэгдэж байна. Тухайлбал, уул уурхайн экспорт, тэр дундаа нүүрсний экспорт өсөж байгаа нь том машин, механизм болон дизель түлшний импортын эрэлт өсөх гол шалтгаан болж байна. Түүнчлэн дотоод эдийн засгийн идэвхжил эрчимжихийн зэрэгцээ төсвийн зардал оны эхний хагаст жилийн 43 хувиар нэмэгдсэн нь импортыг тэллээ.


#### Хүснэгт 4.2 Импортын өсөлт эрчимжиж, II улиралд 27.0 хувьд хүрлээ.

сая ам.доллар	2023 II	2024 II	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
<b>Нийт импорт</b>	<b>2,334</b>	<b>2,964</b>	<b>27.0</b>	<b>27.0</b>
Хэрэглээний бүтээгдэхүүн	672	796	18.5	5.3
Түргэн эдэлгээт	325	394	21.0	2.9
Удаан эдэлгээт	346	402	16.1	2.4
Сүүдлын автомашин	226	256	13.3	1.3
Хөрөнгө оруулалтын бүт.н	993	1,417	42.8	18.2
Нефтийн бүтээгдэхүүн	457	503	10.1	2.0
Дизель	262	312	19.1	2.1
Бусад шатахуун	195	191	-2.1	-0.2
Аж үйлдвэрлэлийн орц	209	244	16.5	1.5
Бусад	3.7	4.7	29.9	0.0

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

**Үйлчилгээний дансны алдагдал** төдийлөн буурахгүй, өндөр хэвээр байна. Үүнд хувийн аялал, боловсрол, эрүүл мэндийн зориулалттай үйлчилгээний зардал тайлант улиралд өмнөх жилийн мөн үеэс 64 сая ам.доллараар нэмэгдсэн нь голлон нөлөөлж байна. Харин үйлчилгээний дансны орлого өмнөх жилийн мөн үеэс төдийлөн сайжраагүй байна (Зураг 4.55).


#### Зураг 4.5 Үйлчилгээний дансны алдагдал өндөр байна.



Эх сурвалж: Монголбанк

**Орлогын дансны алдагдал** II улиралд 819.5 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 230 сая ам.доллараар их байна (Зураг 4.66). Үүнд, дотоодын аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа нэмэгдсэн болон Оюу толгойн зээлийн хүүний хуримтлагдсан хүүний төлбөр өсөж байгаа нь голлон нөлөөлөв.


Зураг 4.6 Орлогын дансны алдагдал тэлж байна.



Эх сурвалж: Монголбанк

**Санхүүгийн дансны тэнцэл 2024 оны II улиралд 197 сая ам.долларын алдагдалтай байна.** Нэг талаас Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилт болон хувийн секторын гадаад зээлийн ашиглалт өндөр байсан нь орох урсгалыг голлон бүрдүүлээ. Харин дотоодын аж ахуй нэгж, банкуудын гадаад ностро дансны үлдэгдэл нэмэгдсэн болон БНХАУ-ын Ардын банктай хийсэн своп хэлцлийн үндсэн төлбөрөөс 621 сая ам.доллар төлөгдсөн нь гарах урсгал тайлант улиралд нэмэгдэхэд нөлөөллөө.

Зураг 4.7 Санхүүгийн данс 2024 оны II улиралд 197 сая ам.долларын алдагдалтай байв.



Эх сурвалж: Монголбанк

